



**WWF Mongolia Programme Office**  
8<sup>th</sup> khoroo  
Sukhbaatar district  
Amar street-4  
Ulaanbaatar  
Mongolia  
Tel:+976 11 311 659  
Fax:+976 11 310 237  
E-mail:info@wwf.mn

## **Ажлын Удирдамж**

**Ажлын байр:** Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн тусламжтайгаар ядуурлыг бууруулах төслийн орон нутгийн зохицуулагч

**Ажиллах газар:** Хэнтий аймаг, Дадал сум

**Тайлагнах хүн:** Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Амар мөрний хөтөлбөрийн менежер  
**Хугацаа:** Нийт 4 жил. Гэрээг нэг жилээр хийж ажлын гүйцэтгэлд үндэслэн жил бүр сунгана.

**Удирдлагад**

**ажиллах хүн:** Төслийн орон нутагт ажиллах ажилтнууд

**Ажиллах газрын**

**хүрээ:** Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адрага, Дадал, Батширээт, Норовлин, Өмнөдэлгэр сум, Дорнод аймгийн Баян-Уул сум

**Ажлын ерөнхий хүрээ:**

- Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжүүлж буй Онон голын савд “Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн тусламжтайгаар ядуурлыг бууруулах” төслийн үйл ажиллагааг төсөл хэрэгжих газар нутагт зохион байгуулна.
- Төслөөс орон нутагт хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг “Тусламжийг хэрэгжүүлэх гарын авлага”-ын дагуу Засгийн газар болон Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын стандарт, журмын хүрээнд зохион байгуулна.
- Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон хандивлагчийн шаардлагын дагуу цаг тухайд гаргаж өгнө.
- Төслийн үйл ажиллагааг бүс нутагт байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна.

**Голлох үүрэг хариуцлага:**

1. Орон нутагт хэрэгжих төслийн үйл ажиллагааг төслийн Удирдах зөвлөлийн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу үр дүнтэй бүрэн хэрэгжүүлнэ.
2. Удирдах зөвлөлийн баталсан ажлын төлөвлөгөөний хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх улирлын ажлын төлөвлөгөөг боловсруулж төсвийн тодотгол хийнэ.
3. Сумдын зохицуулагчдын боловсруулсан хагас жил, улирлын ажлын төлөвлөгөө, төсвийн тодотголуудыг төслийн ажлын ерөнхий төлөвлөгөөтэй (хагас жилийн болон улирлын) нягт уялдуулан тэднийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

4. Төсөлд ажиллах урт, богино хугацааны үндэсний зөвлөх багийн орон нутагт ажиллах нөхцлийг хангах, хүлээгдэж буй үр дүнг төслийн бусад хэсэгтэй уялдуулна.
5. Төслийн явцын, санхүүгийн тайлангуудыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх ба техник ажлын тайланг зөвлөхүүдээс цаг хугацаанд авч явцын тайланд тусгана.
6. Орон нутагт хийгдэх төслийн үйл ажиллагаатай холбоотой захиргаа (тоног төхөөрөмжийн бүртгэл ашиглалт, боловсон хүчин), санхүүгийн бүхий л үйл ажиллагааг удирдана.
7. Орон нутагт хийгдэж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, төслийн урт богино хугацааны зөвлөхүүд, ялангуяа сумдын зохицуулагчдын ажилтай байнга танилцан тэднийг ерөнхий удирдамж, зөвлөгөөгөөр хангана.
8. Төслийн үйл ажиллагааг бүс нутагт хэрэгжиж байгаа бусад төсөл, хандивлагчид, хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай уялдуулна.
9. Олон нийттэй ажиллаж төслийн үйл ажиллагаа, хандивлагчдын талаарх мэдээллийг ард иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.
10. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын удирдлага, Амар мөрний хөтөлбөрийн менежерийн өгсөн бусад холбогдох үүргийг гүйцэтгэнэ.

#### **Тавигдах шаардлага:**

##### Боловсрол

Байгалийн нөөцийн менежмент, хөдөө аж ахуй, бусад холбогдох салбар болон бизнесийн, удирдлагын чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх. Удирдах ажлын туршлагыг дээд боловсролд тавигдах шаардлагатай дүйцүүлэн тооцох боломжтой.

##### Ажлын туршлага

Байгаль хамгаалал, хөдөө аж ахуй, бусад холбогдох салбар эсвэл удирдлагын чиглэлээр дор хаяж 5-8 жил, түүний дотор удирдах албан тушаалд 2-3 жил ажилласан байх.

##### Чадвар мэргэшил

Баг бүрдүүлэн ажиллаж, багийн идэвх санаачлагыг хөхүүлэн дэмжих, тэднийг удирдан залах чадвартай байна.

Олон нийттэй ажиллах, бусдад ажлаа танилцуулах, багаар ажиллах чадвартай байна.

Компютерийн үндсэн програм хангамж дээр ажиллах (MS Word, Excel, Powerpoint), дүн шинжилгээ хийх, төлөвлөх, бие даан шийдвэр гаргаж, ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгэх чадвартай байна.

#### **Сонирхсон хүмүүс өөрийн намтар, өргөдлөө 2008 оны 12 сарын 5-наас өмнө дараах хаягаар илгээх буюу авчирч өгнө үү?**

Дэлхийн байгаль хамгаалах сан  
(WWF)-гийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар  
Амарын гудамж-4  
Сүхбаатар дүүрэг  
8-р хороо  
Улаанбаатар,  
Утас:+976 11 311 659  
Факс:+976 11 310 237  
И-мэйл::info@wwf.mn